



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
 ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 26 өдөр

Дугаар A/47

Алтай хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр Цээл сумд шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуухны ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Л.Отгончимэг - (Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Д.Ууган-Эрдэнэ - (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

М.Хандсүрэн - (Хөндлөнгийн төлөөлөл)
 (тохиролцсоноор)

Нарийн бичиг: Г.Алтангадас - (Есөнбулаг сумын иргэн)
 Б.Батнайрамдал - (Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

2. Тендерийн баримт бичгийг боловсруулан гаргаж, худалдан авах ажиллагааг зохион байгуулан, дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо (Л.Отгончимэг)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ

Д.АЛТАНЗАГАС